



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар A/33

ӨВТ

Г Камержуулах ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3, Коронавируст халдварт (Ковид-19) –ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай" хөтөлбөр батлах тухай 101 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлж, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах зорилгоор Шатахуун түгээх станцууд, аж ахуйн нэгж, байгууллагууд гадна орчныхоо камерын хүчин чадал, тоог нэмэгдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулсугай.

2. Энэхүү ажлыг сумын хэмжээнд чанартай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан), Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн ахлах дэслэгч (Д.Пүрэвдорж) нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Л.БАТЧУЛУУН